



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шинжлэх ухааны академийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/019/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он	МонголУлсын Ерөнхий аудиторын орлогч: Я.Самбууням Утас: 261663 Цахим хаяг: sambuunyam.ya@audit.mn Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Мөнхжин Утас: 261740 Цахим хаяг: munkhjind@audit.gov.mn Аудитор: О.Наранбат Утас: 261740 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ГАЗРЫН ДАРГА  
А.БАЯРБААТАР ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 01/2025  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Шинжлэх ухааны академийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүд нэмэлт санхүүжилтийн дансанд Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос нийт 4,603.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 472 дугаар тогтоолоор нийт 3,307.3 сая төгрөгийн аж үйлдвэрийн оюуны өмч буюу шинэ бүтээл, ашигтай загвар, барааны тэмдгийг биет бус хөрөнгөөр бүртгэсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 214 дүгээр тогтоолоор Шинжлэх ухааны академийн байр, лаборатори, техник, тоног төхөөрөмж зэрэг материаллаг бааз, хүний нөөцөд тулгуурлан ахисан түвшний сургалтын үйл ажиллагаа эрхлэх “Шинжлэх ухааны академийн Их сургууль”-ийг байгуулж, тайлант онд 3 ажилтан цалинжуулан ажиллуулсан байна. Сургалтын байгууллагын үйл ажиллагааг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлж Боловсрол, шинжлэх ухааны яам болон Үндэсний шинжлэх ухааны сангаас нийт 212.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Шинжлэх ухааны академи нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж хүргүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,725,843.2</b>	<b>5,694,131.5</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	981,998.7	399,367.0
33	АВЛАГА	2,806,751.8	2,259,691.3
34	УРЬДЧИЛГАА	127,229.4	216,346.7
35	БАРАА МАТЕРИАЛ	1,809,863.3	2,818,726.5
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>42,291,694.8</b>	<b>50,031,450.8</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	42,291,694.8	50,031,450.8
39200	Биет хөрөнгө	35,670,136.3	40,242,661.3
39300	Биет бус хөрөнгө	6,621,558.6	9,788,789.5
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>48,017,538.0</b>	<b>55,725,582.3</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>42,657.8</b>	<b>17,676.2</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	42,657.8	17,676.2
41300	Өглөг	42,657.8	17,676.2
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>47,974,880.2</b>	<b>55,707,906.1</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	47,974,880.2	55,707,906.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	23,421,829.6	23,421,829.6
51200	Хуримтлагдсан үр дүн	14,216,055.6	21,895,533.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,336,995.0	10,390,543.4
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>48,017,538.0</b>	<b>55,725,582.3</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>52,096,087.5</b>	<b>63,123,131.5</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,329,272.8	11,222,655.4
120	Нийтлэг татварын бус орлого	1,239,745.4	4,718,407.6
122	Тусламжийн орлого	7,089,527.4	6,504,247.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	43,766,814.7	51,900,476.1
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>46,281,405.2</b>	<b>55,338,502.4</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	46,281,405.2	55,338,502.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,951,377.8	54,548,078.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,720,444.7	34,210,695.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,328,362.2	4,095,346.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	812,128.2	850,757.7
2104	Хангамж, бараа материалын зардал	1,229,733.2	1,369,738.1
2105	Норматив зардал	300,823.3	221,096.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	600,192.9	894,107.9
2107	Томилолт, зочны зардал	2,219,102.2	2,379,932.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,356,765.3	4,988,658.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,383,825.7	5,537,745.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,330,027.5	790,423.7
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>5,814,682.2</b>	<b>7,784,629.1</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,000.0</b>	<b>123,932.8</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>5,811,682.2</b>	<b>7,660,696.3</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>52,354,385.5</b>	<b>60,787,507.1</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,089,560.8	6,505,584.2
120	Нийтлэг татварын бус орлого	33.5	1,336.4
122	Тусламжийн орлого	7,089,527.4	6,504,247.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	45,264,824.6	54,281,922.9
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>46,058,491.6</b>	<b>53,993,159.3</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	46,058,491.6	53,993,159.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,376,942.9	51,003,778.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,714,070.5	34,220,472.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,304,746.2	4,099,246.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	810,239.8	853,673.5
2104	Хангамж, бараа материалын зардал	1,151,592.0	1,535,201.6
2105	Нормативт зардал	406,971.7	537,590.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,342,566.8	1,051,280.6
2107	Томилолт, зочны зардал	2,366,575.7	2,549,569.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,553,265.3	5,316,288.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	726,915.0	840,455.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,681,548.7	2,989,380.6
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>6,295,893.9</b>	<b>6,794,347.8</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>5,549,890.3</b>	<b>7,376,979.5</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,549,890.3	7,376,979.5
2200	Дотоод эх үүсвэрээр	5,549,890.3	7,376,979.5
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(5,549,890.3)</b>	<b>(7,376,979.5)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>746,003.6</b>	<b>(582,631.7)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	235,995.1	981,998.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	981,998.7	399,367.0

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>1</b>	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>42,137,644.0</b>	-	<b>42,137,644.0</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(654.3)	-	(654.3)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	42,136,989.7	-	42,136,989.7
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	26,208.3	-	26,208.3
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	5,811,682.2	-	5,811,682.2
<b>10</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>47,974,880.2</b>	-	<b>47,974,880.2</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	18,781.2	-	18,781.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	47,993,661.4	-	47,993,661.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	53,548.4	-	53,548.4
19	Тайлант үеийн үр дүн	7,660,696.3	-	7,660,696.3
<b>20</b>	<b>2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>55,707,906.1</b>	-	<b>55,707,906.1</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>43,462,746,700.00</b>	<b>43,180,411,230.02</b>	<b>282,335,469.98</b>	<b>99.35</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>43,462,746,700.00</b>	<b>43,180,411,230.02</b>	<b>282,335,469.98</b>	<b>99.35</b>
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,999,163,200.00	42,744,407,703.58	254,755,496.42	99.41
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,348,980,500.00	30,261,873,676.68	87,106,823.32	99.71
Үндсэн цалин	19,294,189,500.00	20,139,978,738.81	(845,789,238.81)	104.38
Нэмэгдэл	8,715,423,900.00	6,683,831,020.83	2,031,592,879.17	76.69
Унаа хоолны хөнгөлөлт	1,837,599,600.00	2,075,560,264.45	(237,960,664.45)	112.95
Урамшуулал	501,767,500.00	1,334,136,885.25	(832,369,385.25)	265.89
Гэрээт ажлын хөлс	-	28,366,767.34	(28,366,767.34)	0.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,717,969,300.00	3,629,527,222.41	88,442,077.59	97.62
Тэтгэврийн даатгал	2,518,572,800.00	2,505,031,139.17	13,541,660.83	99.46
Тэтгэмжийн даатгал	304,669,800.00	299,406,357.10	5,263,442.90	98.27
ҮОМШӨ-ний даатгал	149,660,100.00	153,593,226.48	(3,933,126.48)	102.63
Ажилгүйдлийн даатгал	149,364,100.00	132,486,124.27	16,877,975.73	88.70
Эрүүл мэндийн даатгал	595,702,500.00	539,010,375.39	56,692,124.61	90.48
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	844,316,900.00	822,058,050.06	22,258,849.94	97.36
Гэрэл, цахилгаан	453,282,400.00	410,129,015.45	43,153,384.55	90.48
Түлш, халаалт	276,306,300.00	279,904,264.50	(3,597,964.50)	101.30
Цэвэр, бохир ус	83,228,200.00	100,524,770.11	(17,296,570.11)	120.78
Байрны түрээс	31,500,000.00	31,500,000.00	-	100.00
Хангамж, бараа материалын зардал	570,110,700.00	564,677,698.18	5,433,001.82	99.05
Бичиг хэрэг	41,051,300.00	52,771,429.10	(11,720,129.10)	128.55
Тээвэр, шатахуун	30,474,200.00	23,249,035.08	7,225,164.92	76.29
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,614,100.00	41,777,475.00	(13,163,375.00)	146.00
Ном, хэвлэл	337,309,900.00	322,672,985.00	14,636,915.00	95.66
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,898,800.00	11,782,820.00	(2,884,020.00)	132.41
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	123,762,400.00	112,423,954.00	11,338,446.00	90.84
Нормативт зардал	114,110,500.00	112,722,500.00	1,388,000.00	98.78
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	101,777,000.00	101,757,000.00	20,000.00	99.98
Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,333,500.00	10,965,500.00	1,368,000.00	88.91
Эд хогшил, урсгал засварын зардал	3,575,994,100.00	3,564,495,175.91	11,498,924.09	99.68
Багаж, техник, хэрэгсэл	2,740,968,200.00	2,741,270,095.97	(301,895.97)	100.01
Тавилга	38,400,000.00	40,274,300.00	(1,874,300.00)	104.88
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	42,593,400.00	42,583,300.00	10,100.00	99.98
Урсгал засвар	754,032,500.00	740,367,479.94	13,665,020.06	98.19
Томилолт, зочны зардал	516,440,900.00	515,045,013.20	1,395,886.80	99.73
Гадаад албан томилолт	29,657,000.00	29,657,000.00	-	100.00
Дотоод албан томилолт	486,226,500.00	484,830,613.20	1,395,886.80	99.71
Зочин төлөөлөгч хүлээн авах	557,400.00	557,400.00	-	100.00

Шинжлэх ухааны академийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,957,058,700.00	2,920,765,912.87	36,292,787.13	98.77
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,820,798,400.00	2,797,781,241.87	23,017,158.13	99.18
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	33,020,300.00	27,676,200.00	5,344,100.00	83.82
Даатгалын үйлчилгээ	4,679,200.00	2,842,270.00	1,836,930.00	60.74
Тээврийн хэрэгслийн татвар	2,248,700.00	1,526,152.00	722,548.00	67.87
Тээврийн хэрэгслийн оношлогоо	268,200.00	210,100.00	58,100.00	78.34
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	74,582,100.00	74,454,400.00	127,700.00	99.83
Газрын төлбөр	21,057,700.00	16,275,549.00	4,782,151.00	77.29
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	404,100.00	-	404,100.00	0.00
Бараа үйлчилгээний бусад зардал	354,181,600.00	353,242,454.27	939,145.73	99.73
Бараа үйлчилгээний бусад зардал	23,033,800.00	23,015,188.00	18,612.00	99.92
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	331,147,800.00	330,227,266.27	920,533.73	99.72
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>463,583,500.00</b>	<b>436,003,526.44</b>	<b>27,579,973.56</b>	<b>94.05</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	14,753,000.00	14,611,161.17	141,838.83	99.04
Засгийн газрын гадаад шилжүүлэг	14,753,000.00	14,611,161.17	141,838.83	99.04
Бусад урсгал шилжүүлэг	448,830,500.00	421,392,365.27	27,438,134.73	93.89
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	66,925,600.00	66,726,600.00	199,000.00	99.70
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	318,270,600.00	292,311,465.27	25,959,134.73	91.84
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	63,634,300.00	62,354,300.00	1,280,000.00	97.99
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>43,462,746,700.00</b>	<b>43,180,411,230.02</b>	<b>282,335,469.98</b>	<b>99.35</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>43,462,746,700.00</b>	<b>43,179,074,820.67</b>	<b>283,671,879.33</b>	<b>99.35</b>
Улсын төсвөөс санхүүжих	43,462,746,700.00	43,179,074,820.67	283,671,879.33	99.35
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>-</b>	<b>1,336,409.35</b>	<b>(1,336,409.35)</b>	<b>0.00</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,336,409.35	(1,336,409.35)	0.00
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>16</b>	<b>16</b>	<b>-</b>	<b>100.00</b>
Төсвийн байгууллага	16	16	-	100.00
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>1221</b>	<b>1206</b>	<b>15</b>	<b>98.77</b>
Удирдах ажилтан	26	25	(1)	96.15
Гүйцэтгэх ажилтан	1045	1033	(12)	98.85
Үйлчлэх ажилтан	150	148	(2)	98.67

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>11,107,407,969.68</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>11,107,407,969.68</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>8,796,202,811.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	<b>1,724,657,608.61</b>
210101	Үндсэн цалин	-	577,261,676.66
210102	Нэмэгдэл	-	21,772,728.01
210104	Урамшуулал	-	5,911,110.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	1,119,712,093.94
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	<b>200,996,923.19</b>
210201	Тэтгэврийн даатгал	-	200,900,923.19
210202	Тэтгэмжийн даатгал	-	24,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	12,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	12,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	48,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	<b>31,615,485.54</b>
210301	Гэрэл, цахилгаан	-	24,264,459.87
210302	Түлш, халаалт	-	3,242,825.67
210303	Цэвэр, бохир ус	-	4,108,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	<b>919,598,332.76</b>
210401	Бичиг хэрэг	-	116,233,386.00
210402	Тээвэр, шатахуун	-	158,637,490.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	9,266,459.87
210404	Ном, хэвлэл	-	409,995,705.02
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	130,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	225,335,291.87
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	<b>424,867,941.34</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	424,867,941.34
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	<b>1,035,476,690.56</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	951,419,115.56
210602	Тавилга	-	3,853,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	30,128,339.00
210604	Урсгал засвар	-	50,075,936.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	<b>1,880,994,198.50</b>
210701	Гадаад албан томилолт	-	311,028,282.35
210702	Дотоод албан томилолт	-	1,539,582,810.15
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	30,383,106.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	<b>2,226,315,715.57</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,203,161,996.57
210803	Даатгалын үйлчилгээ	-	6,772,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	15,453,000.00
210807	Газрын төлбөр	-	928,719.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>351,679,914.93</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	14,931,269.93
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	336,748,645.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>2,311,205,158.68</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	<b>44,076,711.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	44,076,711.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>2,267,128,447.68</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,267,128,447.68

Шинжлэх ухааны академийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын хураангуй тайлан

<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>11,107,407,969.68</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>11,107,407,969.68</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,332,647,802.42
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	23,144,319.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,148,281,033.13
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,603,334,815.13

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар Шинжлэх ухааны академийн нийт 793.3 сая төгрөгийн 17 алдаа илэрснээс аудитын явцад 793.3 сая төгрөгийн 17 алдааг залрууллаа.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 401.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 11.1 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 111.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 11 албан шаардлага, сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлж, 279.4 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 20 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй 401.9 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 152.7 сая төгрөгөөр бага тул **“Өөрчлөлтгүй”** дүгнэлт өглөө.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 17 төсвийн захирагчийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 хүрээлэнд дүгнэлт гаргаж, 11 хүрээлэнд аудитын түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа хүрээлэнгүүдийн санхүүгийн тайланд 5 **“Өөрчлөлтгүй”** дүгнэлт 1 **“Хязгаарлалттай”** дүгнэлт өгсөн. Палеонтологийн хүрээлэн нь Хязгаарлалттай дүгнэлт авсан байна.

#### 3.1 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 18.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 14.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлж, 3.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 зөвлөмж өгсөн.

##### 3.1.1 Албан шаардлага

1. Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгчийн 2022 оны А/59 дүгээр тушаалд үндэслэн тайлант онд 4 албан хаагчид 1.4 сая төгрөгийн гэрээт ажлын төлбөр олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх онд хэрэгжүүлсэн ажил үйлчилгээний гэрээний төлбөрийг тайлант оны төсвөөс санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

2. Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн газар нь Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд 8.2 сая төгрөгийн ажилчидтай холбоотой өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", МУЕА-

ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.1-т “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайланг бэлтгэхээс өмнө ажилчидтай холбоотой үүссэн өр төлбөрийн тооцоог хянаж, Нийгмийн даатгал болон Татвартай тооцоо нийлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

3. Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн газар нь Төсвийн төсөлд тусгаж төлөвлөөгүй, байгууллагын чиг үүрэгт хамааралгүй Монголын залуу эрдэмтдийн холбооны 20 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулахад заалны түрээсийн төлбөр 5.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын чиг үүрэгт хамааралгүй зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, төсвийн төсөлд тусгаж төлөвлөөгүй, чиг үүрэгт хамааралгүй арга хэмжээнд санхүүжилт олгохгүй байх албан шаардлага хүргүүлээ.

### 3.1.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Урсгал зардалтай холбоотой холбоотой асуудал

Илрүүлэлт: Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн газар нь нэг жилийн хугацаатай тээврийн хэрэгслийн даатгал, лицензийн төлбөрийн тайлант онд ногдохгүй 3.7 сая төгрөгийн зардлыг шууд зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэг жилийн хугацаатай тээврийн хэрэгслийн даатгал, лицензийн төлбөрийг урьдчилж гарсан зардлаар бүртгэж, тайлант хугацаанд хамраах зардлаар хорогдуулан тайлагнах.

#### 2. Харьяа байгууллагын зөрчилтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Харьяа хүрээлэнгүүдэд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 401.9 сая төгрөгийн 38 зөрчил илэрснээс 11.1 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 111.3 сая төгрөгийн 11 албан шаардлага, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлж, 279.4 сая төгрөгийн 20 зөвлөмж өгсөн байна. Энэ нь өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлөөс 9.0 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг, 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, тайлант онд гарсан алдаа, зөрчлийн нийт дүнг 20.0 хувиар бууруулах арга хэмжээ авч ажиллах.

### 3.2 Түүврийн байгууллага

Харьяа хүрээлэнгүүдийн санхүүгийн тайлангийн аудитын нийт 383.6 сая төгрөгийн 33 зөрчил илэрч, 11.1 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт, 96.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 8 албан шаардлага хүргүүлж, 275.7 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 18 зөвлөмжийг өгсөн.

#### 3.2.1 Төлбөрийн акт

**1.Илрүүлэлт:** Технологийн инкубаторын захирлын 2024 оны Б/16 дугаар тушаалаар гадаад албан томилолтын зардлыг 7.5 сая төгрөгөөр баталж, санхүүжилт олгоходоо 0.3 сая төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан "Гадаад албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журмын 2-т Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр 2.2-д "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ" 2.2.1-т "унааны зардал" 2.2.2-д "байрны зардал" 2.2.3-т "хоолны зардал" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Батлагдсан төсвөөс илүү олгосон гадаад албан томилолтын зардлын зөрүүг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

#### 3.2.2 Албан шаардлага

1. Философийн хүрээлэн нь Суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээний эрдэм шинжилгээний зардлын ангилалд тусгаж батлаагүй 0.6 сая төгрөгийн холбооны зардал, 7.9 сая төгрөгийн урамшууллын зардлыг төслийн хөрөнгөөс санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" Монгол Улсын засгийн газрын 2022 оны 497 дугаар тогтоолоор батлагдсан, "Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-тай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Сангаас санхүүжүүлсэн төслийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

2. Технологийн инкубатор нь Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа шууд худалдан авч болох бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарт багтааж, нийт 25.5 сая төгрөгийн ажил, үйлчилгээний гэрээг жижиглэн байгуулж, албан хэрэгцээнд компьютер, тоног төхөөрөмж худалдаж авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын

аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг баримтлаагүй байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа нэр төрөл, ижил төстэй байдлаар нь багц үүсгэж тендер шалгаруулалт зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Технологийн инкубатор нь Төсвийн жил дамнуулан буюу дараа онд хэрэгжүүлэх ажил үйлчилгээний нийт 7.5 сая төгрөгийн гэрээг 2 аж ахуйн нэгжтэй байгуулж, төлбөрийг тайлант оны төсвөөс санхүүжүүлж, шууд зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дараа онд хэрэгжүүлэх ажил үйлчилгээний гэрээний төлбөрийг тайлант оны төсвөөс санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

### 3.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Археологийн хүрээлэн нь Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 22.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил бүртгэлтэй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлд "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэн бүртгэлд тусгах.

Илрүүлэлт 2: Газарзүй, геоэкологийн хүрээлэн нь Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 111.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил бүртгэлтэй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлд "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэн бүртгэлд тусгах.

Илрүүлэлт 3: Философийн хүрээлэн нь Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 60.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил бүртгэлтэй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлд "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэн бүртгэлд тусгах.

### **3. Урсгал зардалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Газарзүй, геоэкологийн хүрээлэн нь Эдийн засгийн ангилал зөрүүлэн Цэвэр, бохир ус 210303 зардлын ангиллаас 2.0 сая төгрөгийн тэтгэмжийн зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант жилд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

#### 4. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 11.9 сая төгрөгийн 9 зөрчил илэрснээс 7.5 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 4.4 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж хүргүүлсэн.

##### 4.1 Төсвийн төвлөрүүлэн захирагч

###### Албан шаардлага:

**Илрүүлэлт:** Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолоор Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүдийн орон тооны дээд хязгаарыг баталсан байна. Тус академийн Харьяа зарим хүрээлэнгүүд цалингийн сандаа багтааж, батлагдсан орон тооноос илүү албан тушаалыг хавсран гүйцэтгүүлж байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Эрдэм шинжилгээний байгууллага, төвийн орон тооны дээд хязгаар, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Батлагдсан орон тооноос илүү албан тушаалыг хавсран гүйцэтгүүлж байгаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

###### Зөвлөмж:

**1. Илрүүлэлт:** Шинжлэх ухааны академийн харьяа зарим хүрээлэнгүүд цаг бүртгэлийн системгүй, ажилчдын цаг бүртгэлд тавих хяналт сул байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.5 "Ажил олгогч ажилтны ажлын цагийн бүртгэлийг хөтлөх үүрэгтэй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Ажилчдын цаг бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулж, анхан шатны баримтад үндэслэн цалин хөлсийг тооцон олгож байх.

**2. Илрүүлэлт:** Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүд жил бүр давтагдах шинжтэй орлогыг төсвийн төсөлд төлөвлөж, орлогын төлөвлөгөө батлуулаагүй боловч

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 4,603.3 сая төгрөгийн нэмэлт орлого олж, зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жил болгон давтагдах шинжтэй орлогын төлөвлөгөөг боловсруулан төсвийн төсөлд тусгаж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлж байх.

#### 4.2 Түүврийн байгууллага

##### Зөвлөмж:

1.Илрүүлэлт: Олон улс судлалын хүрээлэн болон Түүх, угсаатны зүйн хүрээлэн нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан боловсруулж, батлуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-д заасан "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ", 46 дугаар зүйлийн 46.1-д "Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан боловсруулж, батлуулах.

2. Илрүүлэлт: Түүх, угсаатны зүйн хүрээлэн нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар бүлгийн 27 дугаар зүйлийн 8-д заасны дагуу урьдчилан хайгуул, судалгаа хийж, дүгнэлт гаргах ажлын хүрээнд аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж нэмэлт орлого олж байна. Тус ажлын зарцуулалтыг хүрээлэнгийн хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулсан боловч журмыг баримталж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Шинжлэх ухааны академийн түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн хөдөлмөрийн дотоод журамтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний үндсэн дээр олгосон нэмэлт орлогыг байгууллагын дотоод журамд заасан зохицуулалтын дагуу зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Төсвийн шууд захирагч</b>													
1	Биологийн хүрээлэн	4	200,463.0			4	200,463.0	4	200,463.0				
2	Одон орон, геофизикийн хүрээлэн	2	339,199.0			2	339,199.0	2	339,199.0				
3	Палеонтологийн хүрээлэн	5	143,029.5			5	143,029.5	5	143,029.5				
4	Физик технологийн хүрээлэн	2	105,426.8			2	105,426.8	2	105,426.8				
5	Хими, химийн технологийн хүрээлэн	4	5,141.5	1	5,141.5	3	-	4	5,141.5				
<b>Дүн</b>		<b>17</b>	<b>793,259.8</b>	<b>1</b>	<b>5,141.5</b>	<b>16</b>	<b>788,118.3</b>	<b>17</b>	<b>793,259.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Шинжлэх ухааны академийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын хураангуй тайлан

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Төвлөрүүлэн захирагч</b>													
1	Шинжлэх ухааны академи	5	18,230.9			3	14,527.9	2	3,703.0				
	<b>Дүн</b>	<b>5</b>	<b>18,230.9</b>	-	-	<b>3</b>	<b>14,527.9</b>	<b>2</b>	<b>3,703.0</b>	-	-	-	-
<b>Төсвийн шууд захирагч</b>													
1	Философийн хүрээлэн	2	69,165.6			1	8,565.1	1	60,600.5				
2	Газарзүй, гео-экологийн хүрээлэн	2	113,654.6					2	113,654.6				
3	Археологийн хүрээлэн	1	22,875.7					1	22,875.7				
4	Биологийн хүрээлэн	4	22,569.0			1	18,535.0	3	4,034.0				
5	Технологи инкубатор	3	33,410.8	1	310.8	2	33,100.0						
6	Одон орон, геофизикийн хүрээлэн	4	50,812.0	1	4,062.0			3	46,750.0				
7	Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн	5	17,617.2	2	4,475.4	1	-	2	13,141.8				
8	Хими, химийн технологийн хүрээлэн	4	12,237.6			1	-	3	12,237.6				
9	Физик, технологийн хүрээлэн	4	2,780.3	1	339.9			2	2,440.4	1	1		
10	Палеонтологийн хүрээлэн	4	38,515.9	1	1,953.1	2	36,562.8	1	-				
	<b>Дүн</b>	<b>33</b>	<b>383,638.7</b>	<b>6</b>	<b>11,141.2</b>	<b>8</b>	<b>96,762.9</b>	<b>18</b>	<b>275,734.6</b>	<b>1</b>	<b>1</b>	-	-
	<b>Нийт дүн</b>	<b>39</b>	<b>401,869.6</b>	<b>6</b>	<b>11,141.2</b>	<b>11</b>	<b>111,290.8</b>	<b>20</b>	<b>279,437.6</b>	<b>1</b>	<b>1</b>	-	-

Шинжлэх ухааны академийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын хураангуй тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>									
<b>Төсвийн шууд захирагч</b>									
1	Физик технологийн хүрээлэн	1	7,761.2			1	7,761.2		
2	Палеонтологийн хүрээлэн	1	-					1	-
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>7,761.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>7,761.2</b>	<b>1</b>	<b>-</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>									
<b>Төвлөрүүлэн захирагч</b>									
1	Шинжлэх ухааны академи	3	-			1	-	2	-
<b>Дүн</b>		<b>3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>
<b>Төсвийн шууд захирагч</b>									
1	Палеонтологийн хүрээлэн	2	-					2	-
2	Хими химийн технологийн хүрээлэн	1	-			1	-		
3	Олон улс судлалын хүрээлэн	1	-					1	-
4	Түүх, угсаатны зүйн хүрээлэн	2	-					2	-
<b>Дүн</b>		<b>6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>5</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>		<b>11</b>	<b>7,761.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>7,761.2</b>	<b>8</b>	<b>-</b>